

ИЛ БОЛСОН

МАШ НУУЦ

БАТЛАВ:

“ШУНХЛАЙ ТРЕЙДИНГ” ХХК-ийг төлөөлж гүйцэтгэх захирал:

Ж.Мөнхнаран

“ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БАРИЛГА ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН УДИРДАХ ГАЗАР”-ыг төлөөлж газрын дарга, Хурандаа

Х.Батсайхан

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ийг төлөөлж гүйцэтгэх захирал:

Н.Удаанжаргал

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГУРВАЛСАН ГЭРЭЭ

2022 оны 09 сарын 16-ны өдөр

№ ТТЗ-МН22/09

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү “Газрын тосны бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гурвалсан гэрээ” (цаашид “Гэрээ” гэх)-г

Нэг талаас “ШУНХЛАЙ ТРЕЙДИНГ” ХХК-ийг төлөөлж Борлуулалт, маркетинг хариуцсан захирал Ч.Галмөнх (цаашид “Худалдагч” гэх),

Нөгөө талаас Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг “ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН УДИРДАХ ГАЗАР”-ыг төлөөлж Материал хангалтын хэлтсийн дарга, хурандаа Ш.Батдаваа (цаашид “Худалдан авагч” гэх),

Гуравдагч талаас “ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ийг төлөөлж Захиалагчийн хяналтын хэлтсийн дарга Ш.Алтанхуяг (цаашид “Төлбөр төлөгч”, хамтад нь “Талууд” гэх) нар харилцан тохиролцож байгуулав.

1.2. Энэхүү гэрээгээр худалдагч талаас худалдан авагч талд Монгол улсад мөрдөгдөж буй чанар, стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүн (цаашид “Шатахуун” болон “Тос тослох материал” гэх)-ийг нийлүүлэх, худалдан авагч талаас төлбөр төлөгчөөр дамжуулан худалдагч талд захиалга өгөх, хүлээн авах, төлбөр төлөгч талаас нийлүүлсэн шатахуун болон тос тослох материалын төлбөрийг худалдагч талд төлөх, шатахууны зарцуулалтад хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

ХОЁР. ШАТАХУУН НИЙЛҮҮЛЭЛТ

2.1. Нэр төрөл: А80, Аи-92, Дизель түлш, тос, тослох материал

2.2. Нийлүүлэх байршил:

2.2.1. Улаанбаатар төмөр замын Мааньт өртөөнд байрлах Худалдагч талын зөөврийн Шатахуун түгээх станц, Улаанбаатар төмөр замын Рашаант өртөөнд байрлах Худалдагч талын зөөврийн ШТС, Гэрээний хугацаанд Худалдан авагч талын хүсэлтийн дагуу бусад газарт нэмэлтээр байрлуулсан зөөврийн ШТС (Цаашид “Зөөврийн ШТС” гэх);

- 2.2.2. Улаанбаатар хот болон бусад орон нутагт байрлах Худалдагч талын бусад ШТС (Цаашид “Суурин ШТС” гэх);
- 2.2.3. Худалдан авагч талын эзэмшлийн шатахуун хадгалах сав;
- 2.2.4. Худалдагч талын Улаанбаатар агуулах.
- 2.3. Худалдан авагч болон төлбөр төлөгч нь ажлын тоо хэмжээ болон санхүүжилтийн нөөц боломждоо тулгуурлан шатахууны нийлүүлэлтийн хэмжээг сар бүр тооцож, худалдагч талд хүргүүлнэ. Тухайн сард нийлүүлэх шатахууны хэмжээг өмнөх сарын 25-ны өдрийн дотор худалдан авагч талаас төлбөр төлөгчийн цахим шуудан, 27-ны өдрийн дотор төлбөр төлөгч талаас Хавсралт 2-т заасан маягтын дагуу худалдагч талын цахим шуудан руу илгээснээр захиалга өгсөнд тооцно. Тухайн өдөр нь амралтын өдөр таарсан тохиолдолд өмнөх ажлын өдөр захиалга өгнө.
- 2.4. Худалдагч тал нь захиалга хүлээн авснаас хойш хуанлийн 3 хоногийн дотор шатахууныг нийлүүлж эхлэх ба тухайн сар дууссанаар, эсхүл тухайн сард нийлүүлэх шатахууныг бүрэн нийлүүлснээр тухайн сарын шатахууны нийлүүлэлтийг зогсооно.
- 2.5. Худалдан авагч тал нь тухайн сарын захиалгын хэмжээнээс илүү шатахуун худалдан авах тохиолдолд төлбөр төлөгч тал нэмэлт захиалгыг Хавсралт 2-т заасан маягтын дагуу худалдагч талын цахим шуудан руу илгээснээр захиалгыг өгсөнд тооцно.
- 2.6. Зөөврийн ШТС-аас шатахуун нийлүүлэх тохиолдолд худалдан авагч талын албан ёсны тамга, тэмдэг бүхий Хавсралт 3-т заасан зөвшөөрлийн бичгийг үндэслэн олгох бөгөөд тухай бүрд нь орлого, зарлагын баримтыг 2 хувь үйлдэж, худалдагч болон худалдан авагч талууд гарын үсэг зурснаар худалдагч тал шатахууныг нийлүүлсэнд, худалдан авагч тал хүлээн авсанд тооцох ба талууд тус бүр 1, 1 хувийг санхүүгийн баримт болгон хадгална.
- 2.7. Худалдан авагчийн эзэмшлийн саванд шатахуун нийлүүлэх тохиолдолд энэхүү гэрээний Хавсралт 4-д заасан “Эзлэхүүний арга”-аар худалдагчийн саванд буюу шатахуун нийлүүлж буй автоцистерний саванд хэмжилт хийж, хүлээн авах ба тухай бүрд нь орлого, зарлагын баримтыг 2 хувь үйлдэж, худалдагч болон худалдан авагч талууд гарын үсэг зурснаар худалдагч тал шатахууныг нийлүүлсэнд, худалдан авагч тал хүлээн авсанд тооцох ба талууд тус бүр 1, 1 хувийг санхүүгийн баримт болгон хадгална.
- 2.8. Шатахуун нийлүүлэх бүрд худалдагч, худалдан авагч талын гарын үсэг зурж баталгаажуулсан орлого, зарлагын баримтад үндэслэн тухайн сард нийлүүлсэн шатахууны хэмжээг нарийвчлан тооцно.
- 2.9. Тос, тослох материалыг Худалдагч талын Улаанбаатар хотод байрлах агуулахаас худалдан авагч талд нийлүүлнэ.

ГУРАВ. ТӨЛБӨР ТӨЛӨЛТ

- 3.1. Нэгжийн үнэ нь 2.2.1 болон 2.2.3-т заасан байршлаас шатахуун худалдан авах тохиолдолд Хавсралт 1-д заасан томъёонд суурилан тооцсон үнэ, 2.2.4-т заасан байршлаас Аи-92 шатахууныг худалдан авах тохиолдолд тухайн сарын Улаанбаатар агуулахын бөөний үнээр сар бүр шинэчлэн тогтоосон үнэ байна.

Шинэчлэн тогтоосон үнийг дараа сарын 1-нээс 31-ний хооронд мөрдөх ба худалдагч талаас худалдан авагчийн эзэмшлийн шатахуун хадгалах саванд нийлүүлэх үнэ болон худалдагч талын зөөврийн ШТС-аас нийлүүлэх үнийг тус тусад нь тодорхойлж өгнө. Улаанбаатар агуулахын бөөний үнэ гэдэг нь худалдагч талын Улаанбаатар хотод байрлах агуулахаас борлуулах бөөний үнийг ойлгоно.

- 3.2. Тос тослох материалыг худалдагч талын санал болгосон УБ агуулахын үнээр тухай бүрд нь худалдан авна. УБ агуулахын үнэ гэдэг нь худалдагч талын Улаанбаатар хотод байрлах агуулахаас борлуулах бөөний үнийг ойлгоно.
- 3.3. Энэхүү гэрээний 2.2.2-т заасан байршлаас А80, Аи-92, Дт шатахуун худалдан авах тохиолдолд тухайн суурин ШТС-д мөрдөгдөж буй жижиглэнгийн үнийг баримтална.
- 3.4. Худалдагч тал өмнөх сарын 25-наас 30-ны өдрийн хооронд дараа сард мөрдөх үнийг шинэчлэн тооцож, Ашигт малтмал, газрын тосны газраас авсан хил үнийн лавлагааны хамт худалдан авагч болон төлбөр төлөгч талуудад албан бичиг болон цахим шуудангаар хүргүүлнэ.
- 3.5. Худалдагч болон худалдан авагч талууд нь 14 хоног тутам тооцоо нийлж, тооцоо нийлсэн актыг 3 хувь үйлдэх бөгөөд худалдан авагч тал тооцоо нийлсэн актын 1 хувийг орлого хүлээн авсан баримтын хуулбар /хуулбар үнэн тамга дарсан байх/-ын хамт уг актыг үйлдсэнээс хойш ажлын 3 хоногт багтаан төлбөр төлөгч талд хүргүүлнэ.
- 3.6. Төлбөр төлөгч нь сар бүрийн 7-ны өдрийн дотор тухайн сарын захиалгын үнийн дүнгийн 30 /гуч/ хувийг, үлдэгдэл төлбөрийг тооцоо нийлсэн акт хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан доорх данс руу төлнө.

Худалдагчийн банк	Валют	Дансны дугаар
Худалдаа хөгжлийн банк	Төгрөг	406073356
ХААН Банк	Төгрөг	5038026973
Голомт банк	Төгрөг	2105005768

- 3.7. Худалдагч тал нь тооцоо нийлсэн актыг үйлдсэнээс хойш ажлын 3 хоногийн дотор төлбөрийн нэхэмжлэлийг төлбөр төлөгч талд илгээнэ.
- 3.8. Худалдагч тал нь урьдчилгаа төлбөр болон үлдэгдэл төлбөр төлөгдөх бүрд цахим төлбөрийн системд төлбөрийн баримт болон нэмэгдсэн өртгийн албан татварын падааныг үйлдэн төлбөр төлөгч талд илгээнэ.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Худалдагч талын эрх, үүрэг
 - 4.1.1. Монгол улсад мөрдөгдөж буй чанар, стандартын шаардлага хангасан, эрхийн болон биет байдлын доголдолгүй шатахууныг төлбөр төлөгч талын сар бүр захиалсан нэр төрөл, тоо хэмжээгээр гэрээний хугацаанд тасралтгүй нийлүүлэх үүрэгтэй.

- 4.1.2. 2.2.3-т заасан нөхцөлөөр нийлүүлэлт хийх бүрд тухайн шатахууны чанарын паспорт болон бусад дагалдах бичиг баримтыг хамтад нь илгээх үүрэгтэй.
- 4.1.3. Чанар, стандартын шаардлага хангахгүй шатахуун нийлүүлсэн тохиолдолд худалдагч тал нь шаардлага хангасан шатахуунаар ажлын 3 хоногт багтаан солих үүрэгтэй.
- 4.1.4. Гэрээ байгуулснаар өөрт ил болсон худалдан авагч болон төлбөр төлөгч талын аливаа мэдээллийг шууд болон шууд бусаар задруулахгүй байх, зүй бусаар ашиглахгүй байх үүрэгтэй.
- 4.1.5. Төлбөр төлөгч талд 7 хоног бүрийн даваа гаригт өмнөх 7 хоногийн нийлүүлэлт болон хил үнийн өөрчлөлтийн мэдээг цахим шуудангаар илгээх үүрэгтэй.
- 4.1.6. Тухайн сарын нийлүүлэлт тухайн сарын захиалгын 90 хувьд хүрмэгц худалдагч тал худалдан авагч болон төлбөр төлөгч талд мэдэгдэх бөгөөд төлбөр төлөгч талаас нэмэлт захиалга өгөөгүй тохиолдолд тухайн сарын захиалгыг бүрэн нийлүүлмэгц нийлүүлэлтийг зогсоох үүрэгтэй.
- 4.1.7. Худалдан авагч талын сар бүр тооцон ирүүлсэн хэмжээгээр 30 хоногийн нөөцийг өөрийн эзэмшлийн саванд хадгалах үүрэгтэй.
- 4.1.8. Захиалгын дагуу нийлүүлсэн шатахууны үнийг төлбөр төлөгч талаас гэрээнд заасан хугацаанд төлөхийг шаардах эрхтэй.
- 4.1.9. Худалдагч тал захиалга хүлээн авах болон энэхүү гэрээтэй холбоотой аливаа асуудлаар харилцах итгэмжлэгдсэн ажилтан болон түүний цахим шуудангийн хаягийг Хавсралт 5-д зааж өгөх бөгөөд тухайн ажилтныг, эсхүл цахим шуудангийн хаягийг солих тохиолдолд гэрээний бусад талуудад ажлын 3 хоногийн өмнө мэдэгдэх үүрэгтэй.

4.2. Худалдан авагч талын эрх, үүрэг

- 4.2.1. Худалдан авагч тал нь тухайн сард худалдан авах шатахууны хэмжээг тогтоосон норм болон ажлын графикт төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлын мото/цагт үндэслэн тооцож, өмнөх сарын 25-ны өдрөөс өмнө төлбөр төлөгч талд албан бичиг болон цахим шуудангаар ирүүлэх үүрэгтэй.
- 4.2.2. Тухайн сарын захиалгын хэмжээг тооцохдоо 30 хоногийн нөөцийн хэмжээг хамтад нь тооцож төлбөр төлөгч талд ирүүлэх үүрэгтэй.
- 4.2.3. Бодит гүйцэтгэлтэй уялдуулан шатахууны худалдан авалтыг хийх бөгөөд тухайн сарын ажлын гүйцэтгэл төлөвлөснөөс давах тохиолдолд шаардлагатай шатахууны хэмжээг урьдчилан тооцож, шатахуун нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг хангахуйц хугацаанд төлбөр төлөгч талд мэдэгдэх үүрэгтэй.
- 4.2.4. Тухайн сарын захиалгын хэмжээнээс хэтэрсэн худалдан авалтыг төлбөр төлөгч талын зөвшөөрөлгүйгээр худалдан авах эрхгүй.
- 4.2.5. Монгол улсад мөрдөгдөж буй чанар, стандартын шаардлага хангасан шатахуун нийлүүлэхийг Худалдагч талаас шаардах эрхтэй.
- 4.2.6. Чанар, стандартын шаардлага хангаагүй шатахууныг хүлээн авахаас татгалзах эрхтэй.
- 4.2.7. Худалдан авагч тал захиалга өгөх, өөрийн эзэмшлийн саванд шатахуун хүлээн авах болон энэхүү гэрээтэй холбоотой аливаа

асуудлаар харилцах итгэмжлэгдсэн ажилтан болон түүний цахим шуудангийн хаягийг Хавсралт 5-д зааж өгөх бөгөөд тухайн ажилтныг, эсхүл цахим шуудангийн хаягийг солих тохиолдолд гэрээний бусад талуудад ажлын 3 хоногийн өмнө мэдэгдэх үүрэгтэй.

4.3. Төлбөр төлөгч талын эрх, үүрэг

- 4.3.1. Худалдан авагч талаас ирүүлсэн захиалгын болон 30 хоногийн нөөцийн хэмжээг хянаж, баталгаажуулсны үндсэн дээр энэхүү гэрээний 2.3-т заасан хугацаанд худалдагч талд Хавсралт 2-т заасан маягтын дагуу цахим шуудангаар илгээх үүрэгтэй.
- 4.3.2. Тухайн сард нийлүүлсэн шатахууны төлбөрийг худалдагч талаас ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэх болон худалдан авагч талаас ирүүлсэн тооцоо нийлсэн акт, нийлүүлэлтийн хэмжээг тооцсон орлогын баримтын хуулбар /хуулбар үнэн тамга дарсан байх/ зэрэгт үндэслэн энэхүү гэрээний 3.6-д заасан хугацаанд төлөх үүрэгтэй.
- 4.3.3. Шаардлагатай тохиолдолд худалдагч болон худалдан авагч талаас шатахууны нийлүүлэлттэй холбоотой баримт, санхүүгийн тооцоо болон холбогдох бусад мэдээллийг шаардан авах эрхтэй.
- 4.3.4. Төлбөр төлөгч тал нь нийлүүлэлтийн хэмжээг хянах, шаардлагатай гэж үзвэл нийлүүлэлтийг зогсоох эрхтэй.
- 4.3.5. Худалдагч талаас 7 хоног бүрийн даваа гаригт өмнөх 7 хоногийн нийлүүлэлт болон хил үнийн өөрчлөлтийн мэдээг цахим шуудангаар шаардан авах эрхтэй.
- 4.3.6. Төлбөр төлөгч тал нь захиалга өгөх болон энэхүү гэрээтэй холбоотой аливаа асуудлаар харилцах итгэмжлэгдсэн ажилтан болон түүний цахим шуудангийн хаягийг Хавсралт 5-д зааж өгөх бөгөөд тухайн ажилтныг, эсхүл цахим шуудангийн хаягийг солих тохиолдолд гэрээний бусад талуудад ажлын 3 хоногийн өмнө мэдэгдэх үүрэгтэй.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

- 5.1. Төлбөр төлөгч тал нь гэрээний 3.6-д заасан хугацаанд нийлүүлсэн шатахууны үнийг төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувиар алданги тооцон худалдагч талд төлнө.
- 5.2. Худалдагч тал нь гэрээний 2.4-т заасан хугацаанд шатахууныг нийлүүлээгүй, эсхүл шатахууныг тасралтгүй тогтмол нийлүүлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.3 хувийн алданги тооцон төлбөр төлөгч талд төлөхөөс гадна гүйцэтгээгүй үүргийн улмаас төлбөр төлөгч болон худалдан авагч талуудад учирсан хохирол (сул зогсолттой холбоотой зардал, гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүйн улмаас үүсэх алданги гэх мэт)-ыг нөхөн төлнө.
- 5.3. Худалдагч тал нь гэрээний 4.1.7-д заасан үүргээ биелүүлээгүйн улмаас төлбөр төлөгч болон худалдан авагч талуудад үүссэн шатахууны үнийн зөрүүг нөхөн төлнө. Шатахууны үнийн зөрүү гэдэгт худалдагч талын буруутай үйл ажиллагааны улмаас тухайн сарын захиалгыг тухайн сард багтаан худалдан авах боломжгүй байдал үүсэж, дараагийн сард нэмэгдэлтэй үнээр худалдан авсан тохиолдлыг ойлгоно. Худалдан авагч болон төлбөр төлөгч талын буруутай үйл ажиллагааны улмаас тухайн сарын захиалгыг бүрэн худалдаж аваагүй тохиолдлыг үүнд хамааруулан ойлгохгүй.

- 5.4. Худалдагч тал чанар, стандартын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн нийлүүлсэн, эсхүл гэрээнд заасан хугацаанд солиогүйн улмаас үүссэн аливаа хохирлыг төлбөр төлөгч болон худалдан авагч талуудад нөхөн төлнө.
- 5.5. Худалдан авагч тал худалдагч талыг чанар, стандартын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн нийлүүлсэн гэж үзсэн даруйдаа худалдагч талд гомдол гаргана. Энэ тохиолдолд төлбөр төлөгч талд үүссэн нөхцөл байдлын талаар мэдээлэл өгнө.
- 5.6. Худалдагч тал гомдлыг хүлээн авмагц, тухайн шатахууныг хадгалж байсан бүхий л савнаас буюу тухайн шатахууныг анх хадгалж байсан сав, нийлүүлэлт хийгдэх явцад хадгалж байсан сав, нийлүүлсэн сав, чанарын доголдол үүссэн гэж үзэх үед хадгалж байсан сав зэргээс худалдан авагч болон төлбөр төлөгч талуудын итгэмжлэгдсэн ажилтнуудыг байлцуулан дээж авч хөндлөнгийн лабораторид шинжлүүлнэ.
- 5.7. Энэхүү дээжүүдийн хариуг харьцуулан үзэж тухайн шатахууны чанар, стандартын доголдлыг тодорхойлж, буруутай этгээд бүрэн хариуцлага хүлээж, нөхөн төлбөр, хохирлыг барагдуулна.

ЗУРГАА. ФОРС МАЖОР БОЛОН HARDSHIP

- 6.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй /форс мажор/ нөхцөл байдалд байгалийн аюулт үзэгдэл, гэнэт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, тахал, хорио цээр болон бусад байгалийн хүчин зүйлс, цэрэг, дайны үйл ажиллагаа, HARDSHIP нөхцөл байдалд төрийн эрх барих байгууллагын шийдвэр, экспорт, импортын хориг, ажил хаялт, үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолтын улмаас энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно. Хэрэв дээрх нөхцөл байдлууд 20 /хорь/ хоногоос илүү хугацаагаар үргэлжилбэл энэхүү гэрээний аль ч тал нөгөө талдаа мэдэгдэн цуцлах эрхтэй.
- 6.2. Форс мажор нөхцөл байдалд аль ч тал гомдлын шаардлага гаргах ба аливаа алдагдлыг нөхөн төлүүлэхийг шаардах эрхгүй. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тал нөгөө талдаа тийм нөхцөл байдал үүссэн болон арилсан тухай нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ.
- 6.3. HARDSHIP нөхцөл байдалд аль нэг тал үүргээ бүрэн биелүүлэхэд хүндрэл бэрхшээлтэй байгаа тохиолдолд талууд тохиролцож гэрээний нөхцөлийг өөрчлөх, гэрээг цуцлах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.
- 6.4. Форс мажор болон HARDSHIP нөхцөл байдал учирсан болохыг МҮХАҮТ-аар гэрчлүүлнэ.

ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭЛТ

- 7.1. Гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд харилцан тохиролцож, хэлэлцэж эвийн журмаар шийдвэрлэнэ.
- 7.2. Талууд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд Монголын Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.


НАЙМ. БУСАД

- 8.1. Энэхүү гэрээг талууд харилцан тохиролцож 2023 оны 8 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаагаар байгуулав.


- 8.2. Гэрээний хугацаа дуусахад аль нэг тал нь гэрээг цуцлах тухай санал гаргаагүй бол гэрээг анх байгуулагдсан хугацаагаар сунгагдсанд тооцно.
- 8.3. Талууд харилцан тохиролцсоноор гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт өөрчлөлт оруулж, цуцалж болно. Нэмэлт, өөрчлөлт болон гэрээтэй холбоотой аливаа санал, мэдэгдэл, хүсэлтийг бичгээр үйлдэж, ажлын гурваас доошгүй хоногийн өмнө талуудад цахим шуудангаар, эсхүл биечлэн хүргүүлнэ.
- 8.4. Энэхүү гэрээг 4 хувь үйлдэж, талууд гарын үсэг зуран, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно. Гэрээний хувь тус бүр нь хууль зүйн хувьд ижил хүчинтэй бөгөөд худалдагч тал 2 хувь, бусад талууд тус бүр 1 хувийг хадгална.
- 8.5. Гэрээний хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

“Шунхлай Трейдинг” ХХК-ийг төлөөлж:

Борлуулалт, маркетинг хариуцсан захирал
Ч.Галмөнх



Хуулийн зөвлөх
Г.Шижирбаатар




Бөөний борлуулалтын менежер
Д.Энхмандал /91915336/




“Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газар”-ыг төлөөлж:

Материал хангалтын хэлтсийн дарга, хурандаа
Ш.Батдаваа



Шатахууны хангалтын мэргэжилтэн, хошууч
Д.Сүх-Эрдэнэ




Гэрээ, эрх зүйн офицер дэслэгч Г.Батмөнх




“Таван толгой төмөр зам” ХХК-ийг төлөөлж:

Захиалагчийн хяналтын хэлтсийн дарга
Ш.Алтанхуяг



Захиргаа, эрх зүйн хэлтсийн хуулийн мэргэжилтэн А.Учрал



Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч
Б.Отгонбаяр

Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч
Л.Билэгт



2022 оны ... сарын ...-ны өдрийн ... тоот,
 “Газрын тосны бүтээгдэхүүн
 худалдах, худалдан авах гэрээ”-ний
 Хавсралт 1А

Зөөврийн ШТС-аас нийлүүлэх Дизель түлшний үнийн томьёо

Нэр	Код	Нэгж	Роснефть үнэ /сар/	Тайлбар
Орос-Монгол хил дэх даф үнэ	R	ам.дол/тн		Импортлох үнэ /Монгол улсын хил хүртэлх/
Ханш	X	төгрөг/ам.дол		Өмнөх сарын 20-25-ны ХХБ-ны ББус зарах дундаж ханш
Онцгой албан татвар	A	төг/тн		МУЗГ-ын 2018.01.25-ны тогтоолын дагуу
Гаалийн татвар	B	%	5	МУЗГ-ын 2014.02.16-ны 65 тоот тогтоолын дагуу
Албан татвар /замын сан/	D	төг/тн	2,140	МУ-ын автобензин, дилелийн түлшний албан татварын тухай хууль
Хувийн жин	C	кг/литр	0.8450	Барааны дундаж хувийн жин, температураас шалтгаалан хэлбэлзэнэ
Төмөр замын тээврийн зардал	T1	төг/тн	18,050	МУ-ын хилээс агуулах хүртэлх тээвэр, төмөр замын тарифаар
Захиалагчийн талбайд хүргэх тээврийн зардал	T2	төг/тн	17,273	Захиалалгчийн талбайд хүргэх тээвэр, тн.км үнэлгээ нь 200₮, 3 байршлын дундаж 95км
Үйл ажиллагааны зардал	H2	төг/тн	357,000	14 хоног тутам тооцоо нийлсний дагуу төлбөр төлөх нөхцөлөөр зээлийн хүү, агуулахын үйл ажиллагааны зардал
Хэрэглээнээс хамаарах ашгийн хувь	M	%	3	Нийлүүлэгчийн ашгийн түвшин
НӨАТ	V	%	10	НӨАТ-ын тухай хууль
Үнэ	P	төг/литр		$P=ROUND(((R*X)^{(1+B)}+A+D+T1+T2+H2)*C/1000)^{(1+M)^{(1+V)},0)}$

“Шунхлай Трейдинг” ХХК-ийг төлөөлж:

Борлуулалт, маркетинг хариуцсан захирал
 Ч.Галмөнх

Хуулийн зөвлөх
 Г.Шижирбаатар

“Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газар”-ыг төлөөлж:

Материал хангалтын хэлтсийн дарга, хурандаа
 Ш.Батдаваа

“Таван толгой төмөр зам” ХХК-ийг төлөөлж:

Захиалагчийн хяналтын хэлтсийн дарга
 Ш.Алтанхуяг

Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч
 Б.Отгонбаяр


ИЛ БОЛСОН

МАШ НУУЦ


Бөөний борлуулалтын
менежер
Д.Энхмандал /91915336/



Шатахууны хангалтын
мэргэжилтэн, хошууч
Д.Сүх-Эрдэнэ



Нягтлан бодох бүртгэлийн
хэлтсийн нягтлан бодогч
Л.Билэгт



Гэрээ, эрх зүйн офицер
дэслэгч Г.Батмөнх



2022 оны ... сарын ...-ны өдрийн ... тоот,
 "Газрын тосны бүтээгдэхүүн
 худалдах, худалдан авах гэрээ"-ний
 Хавсралт 1Б

Худалдан авагчийн саванд нийлүүлэх шатахууны үнийн томъёо

Нэр	Код	Нэгж	Роснефть үнэ Дт /сар/	Роснефть үнэ Аи-92 /сар/	Тайлбар
Орос-Монгол хил дэх даф үнэ	R	ам.дол/тн			Импортлох үнэ /Монгол улсын хил хүртэлх/
Ханш	X	төгрөг/ам. дол			Өмнөх сарын 20-25-ны ХХБ- ны ББус зарах дундаж ханш
Онцгой албан татвар	A	төг/тн			МУЗГ-ын 2018.01.25-ны тогтоолын дагуу
Гаалийн татвар	B	%	5	5	МУЗГ-ын 2014.02.16-ны 65 тоот тогтоолын дагуу
Албан татвар /замын сан/	D	төг/тн	2,140	25,700	МУ-ын автобензин, дилелийн түлшний албан татварын тухай хууль
Хувийн жин	C	кг/литр	0.8450	0.7600	Барааны дундаж хувийн жин, температураас шалтгаалан хэлбэлзэнэ
Төмөр замын тээврийн зардал	T1	төг/тн	18,050	18,050	МУ-ын хилээс агуулах хүртэлх тээвэр, төмөр замын тарифаар
Захиалагчийн талбайд хүргэх тээврийн зардал	T2	төг/тн	29,091	29,091	Захиалалгчийн талбайд хүргэх тээвэр, тн.км үнэлгээ нь 200₮, 3 байршлын дундаж 95км
Үйл ажиллагааны зардал	H2	төг/тн	221,000	221,000	14 хоног тутам тооцоо нийлсний дагуу төлбөр төлөх нөхцөлөөр зээлийн хүү, агуулахын үйл ажиллагааны зардал
Хэрэглээнээс хамаарах ашгийн хувь	M	%	3	3	Нийлүүлэгчийн ашгийн түвшин
НӨАТ	V	%	10	10	НӨАТ-ын тухай хууль
Үнэ	P	төг/литр			$P = \text{ROUND}(((R \cdot X) \cdot (1+B) + A + D + T1 + T2 + H2) \cdot C / 1000) \cdot (1+M) \cdot (1+V), 0)$


“Шунхлай Трейдинг” ХХК-ийг төлөөлж:
 Бэрлуулалт, маркетинг
 хариуцсан захирал
 Ч.Галмөнх

“Зэвсэгт хүчний Барилга-
 инженерийн цэргийн
 удирдах газар”-ыг
 төлөөлж:


“Таван толгой төмөр зам”
 ХХК-ийг төлөөлж:

Захиалагчийн хяналтын
 хэлтсийн дарга
 Ш.Алтанхуяг

Хуулийн зөвлөх
Г.Шижирбаатар




Бөөний борлуулалтын
менежер
Д.Энхмандал /91915336/




Материал хангалтын
хэлтсийн дарга, хурандаа
Ш.Батдаваа



Шатахууны хангалтын
мэргэжилтэн, хошууч
Д.Сүх-Эрдэнэ




Гэрээ, эрх зүйн офицер
дэслэгч Г.Батмөнх



Нягтлан бодох бүртгэлийн
хэлтсийн нягтлан бодогч
Б.Отгонбаяр



Нягтлан бодох бүртгэлийн
хэлтсийн нягтлан бодогч
Л.Билэгт



2022 оны ... сарын ...-ны өдрийн ... тоот,
 “Газрын тосны бүтээгдэхүүн
 худалдах, худалдан авах гэрээ”-ний
 Хавсралт 1В

2022 оны ... сарын шатахуун нийлүүлэх үнэ

№	Нэр төрөл	Байршил	Үнэ ₮/литр	Тайлбар
1	Дт	Гэрээний 2.2.1-д заасан буюу зөөврийн ШТС		Томьёонд суурилсан
2	Дт	Гэрээний 2.2.2-д заасан буюу бусад ШТС		Тухайн үед мөрдөгдөж буй жижиглэнгийн үнэ
3	Дт	Гэрээний 2.2.3-д заасан буюу худалдан авагчийн эзэмшлийн сав		Томьёонд суурилсан үнээс ШТС-ын үйл ажиллагааны зардал хасагдсан үнэ
4	А80	Гэрээний 2.2.2-д заасан буюу бусад ШТС		Тухайн үед мөрдөгдөж буй жижиглэнгийн үнэ
5	Аи92	Гэрээний 2.2.3-д заасан буюу худалдан авагчийн эзэмшлийн сав		Томьёонд суурилсан үнээс ШТС-ын үйл ажиллагааны зардал хасагдсан үнэ
6	Аи92	Гэрээний 2.2.2-д заасан буюу бусад ШТС		Тухайн үед мөрдөгдөж буй жижиглэнгийн үнэ
7	Аи92	Гэрээний 2.2.4-д заасан буюу худалдагчийн УБ агуулах		Тухайн үед мөрдөгдөж буй улаанбаатар агуулахын бөөний борлуулалтын үнэ

“Шунхлай Трейдинг” ХХК-ийг төлөөлж:

Борлуулалт, маркетинг хариуцсан захирал

Ц.Галмөнх

Хуулийн зөвлөх
Г.Шижирбаатар

Бөөний борлуулалтын менежер

Д.Энхмандал /91915336/

“Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газар”-ыг төлөөлж:

Материал хангалтын хэлтсийн дарга, хурандаа
Ш.Батдаваа

Шатахууны хангалтын мэргэжилтэн, хошууч
Д.Сүх-Эрдэнэ

Гэрээ, эрх зүйн офицер дэслэгч Г.Батмөнх

“Таван толгой төмөр зам” ХХК-ийг төлөөлж:

Захиалагчийн хяналтын хэлтсийн дарга
Ш.Алтанхуяг

Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч
Б.Отгонбаяр

Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч
Л.Билэгт

2022 оны ... сарын ...-ны өдрийн ... тоот,
 “Газрын тосны бүтээгдэхүүн
 худалдах, худалдан авах гэрээ”-ний
 Хавсралт 2

Захиалга өгөх хуудас

Зориулалт	Газрын тосны бүтээгдэхүүний нэр төрөл	Нийлүүлэх байршил	Нэгжийн үнэ /₮/	Хэмжээ /тн/
Төслийн талбайд	A80			
	Аи-92			
	Дт			
	ТТМ			
Удирдлагын хэрэглээ	A80			
	Аи-92			
	Дт			
30 хоногийн нөөц хадгалах хэмжээ	A80	Худалдагчийн саванд хадгалах		
	Аи-92			
	Дт			
ТТМ				

“Шунхлай Трейдинг” ХХК-ийг төлөөлж:

Борлуулалт, маркетинг хариуцсан захирал
 Ч.Галмөнх

Хуулийн зөвлөх
 Г.Шижирбаатар

Бөөний борлуулалтын менежер
 Д.Энхмандал /91915336/

“Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газар”-ыг төлөөлж:

Материал хангалтын хэлтсийн дарга, хурандаа
 Ш.Батдаваа

Шатахууны хангалтын мэргэжилтэн, хошууч
 Д.Сүх-Эрдэнэ

Гэрээ, эрх зүйн офицер дэслэгч Г.Батмөнх

“Таван толгой төмөр зам” ХХК-ийг төлөөлж:

Захиалагчийн хяналтын хэлтсийн дарга
 Ш.Алтанхуяг

Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч
 Б.Отгонбаяр

Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч
 Л.Билэгт

2022 оны ... сарын ...-ны өдрийн ... тоот,
“Газрын тосны бүтээгдэхүүн
худалдах, худалдан авах гэрээ”-ний
Хавсралт 3

Зөвшөөрлийн бичиг

Огноо	Машины марк	Машины улсын бүртгэлийн дугаар	Шатахууны төрөл	Олгох хэмжээ	Олгох байршил

Жич: энэхүү маягыг жижигрүүлсэн хувилбараар ашиглах

Зөвшөөрөл олгосон:

Зэвсэгт хүчний жанжин штаб

.....

2022 оны ... сарын ...-ны өдрийн ... тоот,
“Худалдах, худалдан авах
гэрээ”-ний
Хавсралт 4

Орлого хүлээн авахад хэмжилт хийх тухай

Шатахуун, тосолгооны материал нь температураас хамаарч хувийн жин нь өөрчлөгдөж, эзэлхүүн нь ихсэж багасдаг, харин масс нь өөрчлөгдөхгүй онцлог бүтээгдэхүүн учраас хүлээн авах тухайн үеийн хэмжилтийг маш үнэн зөв хийж, орлогоо бүрэн гүйцэт хүлээн авах нь чухал байдаг. “ШТМ-ыг эзэлхүүний аргаар тооцож, хүлээн авах журам”-ыг нефтийн салбарт ажиллаж байгаа бүх аж ахуйн нэгжүүд дагаж мөрдөж байгаа бөгөөд хэмжилт хийхэд анхаарах гол зүйлүүдийг товч танилцуулж байна.

I. Хэмжилт хийх тухай

1. Тухайн автоцистерний баталгаат багтаамжийг тодорхойлсон “цагаан хил” буюу түвшин заагчаас шатахууны хөөрсөн буюу суусан хэмжээг мм-ийн нарийвчлалтайгаар хэмжинэ.
2. Бортогонд дээж авч тухайн үеийн хувийн жин, температурыг хэмжинэ. Ингэхдээ бортогыг тухайн бүтээгдэхүүнээр эхлээд зайлж, дараа нь торхон дахь шатахууны 1/3 түвшнээс дээж авч денсиметрээ 2-оос багагүй минут байлган хөдөлгөөнгүй тогтсоны дараа шатахууны түвшинтэй харалдаа зааж байгаа хэмжээг тэмдэглэж авна. Температурын заалтыг авахдаа денсиметрийн ёроолыг шатахуунаас гаргахгүйгээр харна.

II. Тооцоолол хийх

1. Хүснэгт №01-ийн дагуу агуулахаас ачигдсан үеийнхээс тухайн үеийн хэмжилт хийх хүртэл температур хэдээр өөрчлөгдсөнийг тоолж хувийн жин зөв ирсэн эсэхийг шалгана.
2. Агуулахаас ачигдсан хүндээс тухайн хэрэглэгч хүртэл хэдэн км зайд тээвэрлэгдсэнээс хамааран тээвэрлэлтийн хэвийн хорогдол нь тээвэрлэгдсэн жингээс хувиар тооцогдон хасагдаж очих ёстой. Тухайн зай болон нефтийн бүтээгдэхүүний төрлөөс хамаарсан коэффициентийг авна.
3. Агуулахаас ачигдсан хүндээс тээвэрлэлтийн хэвийн хорогдлыг хасаад өөрийн хэмжсэн хувийн жинд хуваахад тухайн цэг дээр ирсэн байх ёстой ачааны эзэлхүүний хэмжээ гарна.
4. Бодит ирсэн хэмжээг хөөрөлт, суултыг өөрөө хэмжиж авсан хэмжээг литрт шилжүүлэн тухайн торхны баталгаат багтаамж дээр нэмэх эсвэл суусан бол хасч тооцож гаргана.
5. Ирвэл зохих хэмжээ, ирсэн хэмжээ хоёрын зөрүүгээр тухайн бүтээгдэхүүн дутагдсан эсэхийг тооцож гаргана.

III. Хариу падаан бичих

1. Хэрвээ ачаа нь зөрүүгүй ирсэн бол хүлээн авсан хариу падааныг бичиж явуулна. Падааны жинхэнэ хүлээн авахад гэсэн хэсэг дээр агуулахаас ачигдсан хүндийг өөрийн үзсэн хувийн жинд хувааж хүлээн авсан литрийг бичиж явуулна.

2. Ачааг дутагдуулсан бол хувийн жин, температурын хамаарлыг шалгахад ачуулагчийн үзсэн хувийн жин алдаатай буюу өсгөж бичсэн хувийн жинд ноогдох хэмжээг ачаа илгээгч дээр бичнэ. Харин хувийн жин зөрүүгүй боловч ачаа дутсан бол тээвэрлэгч хариуцах гэсэн хэсэг дээр бичиж, тухайн үед нь жолоочоор зөвшөөрүүлэн гарын үсэг зуруулсан байх ёстой.

“Шунхлай Трейдинг” ХХК-ийг төлөөлж:
Борлуулалт, маркетинг хариуцсан захирал
Ч.Галмөнх

Хуулийн зөвлөх
Г.Шижирбаатар

Бөөний борлуулалтын менежер
Д.Энхмандал /91915336/

“Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газар”-ыг төлөөлж:

Материал хангалтын хэлтсийн дарга, хурандаа
Ш.Батдавга

Шатахууны хангалтын мэргэжилтэн, хошууч
Д.Сүх-Эрдэнэ

Гэрээ, эрх зүйн офицер дэслэгч Г.Батмөнх

“Таван толгой төмөр зам” ХХК-ийг төлөөлж:

Захиалагчийн хяналтын хэлтсийн дарга
Ш.Алтанхуяг

Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч
Б.Отгонбаяр

Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч
Л.Билэгт

022 оны ... сарын ...-ны өдрийн ... тоот,
 “Худалдах, худалдан авах
 гэрээ”-ний
 Хавсралт 5

Итгэмжлэгдсэн албан тушаалтан

Гэрээний тал	Албан тушаалтан	Цахим хаяг	Утасны дугаар	Хариуцах асуудал	Гарын үсэг
Худалдагч	Бөөний борлуулалтын менежер	Ennkmandal.D@shunkhlai.mn	91915336	Захиалга хүлээн авах, бусад	
				Тооцоо нийлэх	
Худалдан авагч	Шатахууны хангалтын мэргэжилтэн, хошууч Д.Сүх-Эрдэнэ	Ssvkee649@gmail.com	80022550	Захиалга өгөх, бусад	
	Шатахууны хангалтын мэргэжилтэн, хошууч Д.Сүх-Эрдэнэ	Ssvkee649@gmail.com	80022550	Тооцоо нийлэх	
Төлбөр төлөгч	Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга Г.Жаргалсайхан	jargalsaikhan@ttz.mn		Захиалга өгөх, бусад	
	Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч Б.Отгонбаяр	Otgonbayar_uv@yahoo.com		Тооцоо нийлэх	

“Шунхлай Трейдинг” ХХК-ийг төлөөлж:

Борлуулалт, маркетинг хариуцсан захирал

Ч.Галмөнх

Хуулийн зөвлөх
Г.Шижирбаатар

“Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газар”-ыг төлөөлж:

Материал хангалтын хэлтсийн дарга, хурандаа
Ш.Бат-аваа

Таван толгой төмөр зам” ХХК-ийг төлөөлж:


Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч
Б.Отгонбаяр

Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч
Н.Билэгт


ИЛ БОЛСОН

МАШ НУУЦ

Бөөний борлуулалтын
менежер
Д.Энхмандал /91915336/



Шатахууны хангалтын
мэргэжилтэн, хошууч
Д.Сүх-Эрдэнэ



Гэрээ, эрх зүйн офицер
дэслэгч Г.Батмөнх

